

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД  
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**/ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН  
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО/**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу хийсэн болно.

**Зардал үүсэх субъект:**

Хуулийн төслөөр 1990 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн тухай хуульд төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоохоор заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлөөр 1997 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл биш бөгөөд уг харилцааг одоо 1994 онд батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулж байгаа болно. Иймд хуулийн төсөл нь дээрхи хуульд нэмэлт оруулах хэлбэрээр бичигдсэн байна.

Манай улсад тэтгэвэр олгохтой холбоотой асуудлыг анх 1958 онд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэврийн хууль"-ийг Ардын Их Хурлын чуулганаар батлан хэрэгжүүлж байсан.

Тэтгэврийн харилцааг холбогдох хууль гарснаар 1958 оноос зохицуулж ирсэн тул дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд төрийн холбогдох байгууллагууд, иргэн, хуулийн этгээд нь уг харилцаанд тус тусын үүрэгтэйгээр оролцож ирсэн байна. Иймд дээрх хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдэд шинэ төрлийн үүрэг үүсгээгүй байх тул иргэн, хуулийн этгээдэд зардал бий болгохгүй гэж үзсэн болно.

Харин гуравдагч зардал тээгч субъект болох төрийн байгууллага /улсын төсөв/-д тодорхой төрлийн зардал бий болгосон байх тул хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогdon улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолов.

Тэтгэврийн асуудал эрхэлсэн байгууллагаас бусад байгууллагад аргачлалд заасан төрийн байгууллагад үүсч болох аль ч төрлийн зардал үүсэхээргүй байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд нэмэлт оруулах болсон гол үндэслэлийг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь 1990 онд батлагдсан БНМАУ-ын Тэтгэврийн хуульд

төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоохоор заасны дагуу болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлөөр 1997 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон эхчүүд тухайн үед өндөр насны тэтгэвэр тогтоох насанд хүрээгүй ч хүүхдийн тоогоор насны тэтгэвэр тогтоолгож одоог хүртэл авч байгаа эхчүүдэд хамаарах зохицуулалтыг нэмэх шаардлагатай гэж үзсэн байна.

2018 оны байдлаар улсын дундаж тэтгэврийн хэмжээ нь 342,8 мянган төгрөг байна.

Иймд аргачлалын дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах төслийн хүрээнд уг харилцаанд оролцогч төрийн байгууллагуудын тухайд чиг үүрэг нэмэгдээгүй байх тул улсын төсөвт буй төрийн дээрх байгууллагуудад "хүний нөөцийн болон материаллаг" зардал үүсэхгүй болно.

Гагцхүү хуулийн төслөөр санхүүжилттэй холбоотой зохицуулалтаас хамааран уг асуудлыг шийдвэрлэхийн тулд дараахь төрлийн "шууд /нэмэлт/ зардал" үүсгэхээр байна. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмсүгэй:

"7.1990 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн тухай хуульд төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоохоор заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгоно.

8.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт хамаарахгүй боловч энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлөөр 1997 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгоно." гэжээ.

Иймээс дээрх зохицуулалтад хамаарах эхчүүдийн тоог гаргах, тэдэнд олгогдож байгаа тэтгэврийн хэмжээг тодорхойлох, тэдний тэтгэврийг улсын хэмжээнд байгаа дундаж тэтгэврийн хэмжээнд хүргэхэд шаардагдах санхүүжилтийг тооцон гаргах нь зүйтэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан судалгаанаас үзэхэд

**ХӨНГӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР 1997 ОНООС ӨМНӨ ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР  
ТОГТООЛГОСОН ИРГЭДИЙН ТЭТГЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

Тэтгэврийн төрлөөр	Хүний тоо	Дундаж тэтгэвэр /мян.төг/	Тайлбар

1	Нийтдээ 32 жил ажиллаж, 55 нас хүрч тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй	1,865	404.11	НДСангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ /342.8 мянган төгрөг/-нээс 61.3 мянган төгрөгөөр илүү тэтгэвэр авч байна.
2	Нийтдээ 27 жил ажилласан, нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй	4,025	337.29	НДСангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ /342.8 мянган төгрөг/-нээс 5.5 мянган төгрөгөөр бага тэтгэвэр авч байна.
3	Хүүхдийн болзоор тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй	15,440	315.86	НДСангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ /342.8 мянган төгрөг/-нээс 27.0 мянган төгрөгөөр бага тэтгэвэр авч байна.
	<b>Нийт дүн</b>	<b>21,330</b>	<b>327.62</b>	<b>НДСангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ 342.79 төгрөг</b>

Үүнээс

1	Дундаж тэтгэвэр нь 280.0 мянган төгрөгөөс 333.6 мянган төгрөгийн хооронд тэтгэвэр авч байгаа иргэдийн тоо	18,658	305.08	1997 оны 2 сараас "нэхэн олговор"-т шилжсэн 21.3 мянган тэтгэвэр авагчдын 87.5 % буюу 18.6 мянган тэтгэвэр авагч НДСангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ /342.8 мян.төг/-нээс 62.8-37.7 мянган төгрөгөөр бага тэтгэвэр авч байна.
---	-----------------------------------------------------------------------------------------------------------------------	--------	--------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Иймд дээрх 18.6 мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээнд ойртуулахын тулд 280.0 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг иргэдийн тэтгэврийн хэмжээг  $70.0 / 280.0 + 70.0 = 350.0$  мянган төгрөг/ мянган төгрөгөөр, дунджаар 280.1-350.0 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг иргэдийн тэтгэврийн хэмжээг 50.0 мянган төгрөгөөр, нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоог гаргахад:

Хувилбар 1		Хүснэгт-1 /мян.төг/		
№	Дундаж тэтгэврийн хэмжээ /мян.төг/	Хүний тоо	Нэмэгдүүлэх хэмжээ	Жилд зарцуулах хөрөнгө
1	280 000 төгрөг	3,828	70.0	3,215,520.0
2	280 001 төгрөгөөс 350 000 төгрөг хүртэл	14,830	50.0	8,898,000.0
<b>Нийт дүн</b>		<b>21,330</b>		<b>12,113,520.0</b>

-----ооо-----

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,  
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН  
СУДАЛСАН ТАЙЛАН**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Нийгмийн хамгааллын хууль тогтоомж нь нийгмийн хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор шинэчлэн өөрчлөгдсөөр байна. 1921-1990 онуудад Монгол улсын баримталж ирсэн нийгмийн хамгааллын бодлого нь хүн амынхаа сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах, мэргэжил эзэмших болон хөдөлмөрийн чадвараа алдах, тэтгэвэрт гарах, хүүхэд төрүүлэх, тахир дутуу болох зэрэг тохиолдлуудад шаардлагатай дэмжлэг туслалцааг төрөөс үнэ төлбөргүйгээр үзүүлэх зарчимд үндэслэн хөгжиж ирсэн.

Тэтгэвэр тогтоох асуудлыг анх 1958 онд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэврийн хууль”, 1984 онд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хууль”- ийг Ардын Их Хурлын чуулганаар, батлан хэрэгжүүлж байсан.

1990 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;” хэмээн заасан.

1990 оноос хойш зах зээлийн харилцаанд шилжсэнээр өмнөх нийгмийн хамгааллын тогтолцоог өөрчилж, төр, засгаас хүн амынхаа амьдралын баталгааг хангахын тулд зах зээлийн харилцаанд зохицсон эрх зүйн шинэчлэлтийг хийж эхэлсэн байна. Тухайлбал 1990-1991 онд Улсын Бага Хурлаас “Монгол улсын тэтгэврийн тухай хууль”, “Монгол улсын нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль”, ахмад настан, тахир дутуу иргэд, амьдрал ядуу, бага орлоготой хүмүүсийн талаар Засгийн газрын тогтоолууд гарч хүн амын нийгмийн хамгааллын талаар тодорхой арга хэмжээг авчээ.

Нийгмийн хамгааллын тогтолцоог зах зээлийн харилцаа, дэлхий жишигт нийцүүлэн шинэчлэх асуудлыг үргэлжлүүлэн Улсын Их Хурлаас 1993 онд “Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль”, 1994 онд “Нийгмийн даатгалын тухай багц хууль”, 1995 онд “Нийгмийн халамжийн тухай багц хууль”, 1996 онд “Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого” хэмээх баримт бичгийг батлан гаргажээ.

Эрх зүйн шинэчлэлт хийгдсэнээр иргэдийн өвчлөл, өтлөлт, хөдөлмөрийн чадвар алдалт, осол, гэмтлийн эрсдэлийг нийгмийн даатгал, халамжийн арга хэмжээгээр дамжуулан хамгаалах нийгмийн хамгааллын тогтолцоо бий болсон.

Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 1999 оны 5 дугар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолоор “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”-ийг тодорхойлж, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийг батлан мөрдүүлсэн.

Улс орны нийгэм эдийн засгийн байдал болон хүн ам зүйн бүтцийн өөрчлөлтийг үндэслэн Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 53 дугаар тогтоолоор “Төрөөс тэтгэврийг шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-ийг шинэчлэн баталжээ.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлд “2.1.1. Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;”, “3.2.16. тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;”-аар заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “3.23. Тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлнэ.”, “3.3.24. Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.” гэж тус тус заасан. Эдгээр зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарaad байна.

## УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын<sup>1</sup> /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

БНМАУ-ын Тэтгэврийн хууль 1990 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдаж, 1991 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн.

Энэ хуулийн 11 дүгээр зүйлд эхчүүдийн насны тэтгэвэр тогтоолгох эрхийн тухай заасан ба үүнд: “Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн эхчүүд ...20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй” гэжээ.

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

1990 оны Тэтгэврийн хууль нь тэтгэвэр авагчдын хүрээг өргөтгөх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн эрхийн харилцааны талаарх олон хууль тогтоомжийг нэгтгэн эрх зүйн нэгдсэн зохицуулалтад оруулах, эмэгтэйчүүдийг онцгойлон үзэж хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх чиглэлийг гол зорилго болгосон хэдий ч дээр дурдсан заалтыг ажил олгогчид завшаан болон ашиглаж, олон эмэгтэйчүүдийг ид хийж бүтээх насанд нь буюу 35-45 насанд нь тэтгэвэрт албадан шахуу гаргасан байна.

Хууль болон хууль хэрэгжүүлэхээр гаргасан холбогдох шийдвэр нь дээрх насын эмэгтэйчүүд өөрөөс үл хамаарах шалтгаанаар ажил, хөдөлмөр эрхлэх боломжкоо алдсан буюу хөдөлмөрлөх эрхээ эрт хасуулж, олон арван жилийн туршид тэдгээр эмэгтэйчүүд, тэдний гэр булийнхний эрх ашгийг хохирооход хүргэсэн шийдвэр болжээ.

Хэдийгээр тэр засгаас тодорхой арга хэмжээ авч ирсэн боловч одоо ч эдгээр эхчүүдийн тэтгэврийн хэмжээ улсын дундаж тэтгэврийн хэмжээнд хүрэхгүй байна.

Иймд Аргалчлалын З-д заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

### **1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:**

Нийгмийн даатгалын талаархи хууль тогтоомж, төрөөс тэтгэврийн талаар баримтлах үндсэн чиглэл болон иргэдийн санал, хүсэлт, холбогдох байгууллагаас гаргасан судлагаа, мэдээлэл зэргийг судалж үзсэн болно.

Тухайлбал, Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, "Нийгмийн хамгааллын үнэлгээнд сууриссан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал" НҮБ, ОУХБ, Монгол Улсын засгийн газраас 2015 онд хэвлүүлсэн тайлан, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны материал зэрэг болно.

### **1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:**

Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд "2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно", Арван есдүгээр зүйлд "1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус заасан.

1990 оны Тэтгэврийн тухай хуулиар эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн хувьд сэргөөр нөлөөлөх байдлыг дараахь байдлаар тодорхойлж байна. /Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан судалгааны үндсэн дээр/

1990 оны Тэтгэврийн хуульд төрүүлсэн болон З хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоох болзлыг шинээр оруулан хэрэгжүүлснээр 1991 онд 32,8 мянган эх насны тэтгэвэр тогтоолгосон байна.

1991 онд 288,5 мянган хүн тэтгэвэр авч байсан ба нийт тэтгэвэр авагчдын 45,9 хувь нь буюу 132,4 мянган хүн наснаасаа эрт тэтгэвэр тогтоолгосны дотор 83,3 мянган хүн буюу 62,9 хувь нь эмэгтэйчүүд байсан байна.

Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээний тухай" 5 дугаар тогтоолоор 1995 оноос өмнө Тэтгэврийн хуулиар насны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэврийн насны болзол, нөхцөлийг хангаагүй 44,4 мянган иргэдийн тэтгэврийг түдгэлзүүлж, авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн нийлбэрийн хэмжээтэй тэнцэх "нөхөн олговор"-ыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан сар бүр олгох шийдвэрийг гаргасан юм.

Үүнээс хойш 2017 он гэхэд дээр дурдсан 44,4 мянган иргэн өндөр насны тэтгэврийн насанд хүрснээр нийгмийн даатгалын тэтгэвэрт бүрэн шилжиж дууссан.

Эдгээр иргэдээс 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 21,3 мянган иргэн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа бөгөөд эдгээрийн 15,4 мянга буюу 72,3 хувь нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд, 4,0 мянга буюу 18,9 хувь нь 27 жил ажиллан нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд, 1,8 мянга буюу 8,7 хувь нь 32 жил ажиллан 55 насанд хүрсэн эрэгтэйчүүд эзэлж байна.

1997 оны 02 дугаар сараас өмнө хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эхчүүдээс 18,6 мянга буюу 87,5 хувь нь 2018 оны улсын дундаж тэтгэвэр /342,8 мян.төгрөг/-ээс бага тэтгэвэр авч байна.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эхчүүдээс 3,6 мянга нь бүрэн тэтгэврийн доод хэмжээ /280,0 мянган төгрөг/-ний, 7,6 мянга нь 280,0-300,0 мянган төгрөгийн хооронд тэтгэвэр авч байгаа нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд харьцангуй бага тэтгэвэр авч байгааг харуулж байна.

Бодит байдал, холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд тэтгэвэр олголтын асуудлын хүрээнд яаралтай шийдвэрлэвэл зохих асуудал байсаар байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээ шат дараатай авч хэрэгжүүлсний үр дүнд иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхийг нийгмийн даатгалын харилцаагаар баталгаатай зохицуулах эрх зүй, эдийн засгийн нөхцөл байдал бий болж байгаа билээ.

Хэдий тийм ч энэ хугацаанд дээр дурдсан эхчүүд харьцангуй бага тэтгэвэр авсаар өнөөдрийг хүрсэн байна.

Үүнээс дүгнэхэд нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх үзэл баримтлалаа тууштай тогтоож хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

### **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

### **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг судалж, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу "олон хүүхдээр тэтгэвэрт гарсан эхчүүдийн тэтгэврийг улсын дундаж тэтгэвэрт хүргэх" зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлэх боломжтой	Тодорхой үр дүнд хүрэхгүй

3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгыг хангах боломжгүй	Тодорхой зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нэлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Зорилгыг хангаж чадахгүй.	Тодорхой зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нэлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Зорилгыг хангах боломжгүй. Хуулиар тогтоосон асуудлыг захиргааны шийдвэрээр өөрчлөх боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нэлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуульд нэмэлт оруулах замаар зорилгыг хангах боломжтой.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэх боломжтой.	Үр дүнтэй

Асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд нэмэлт оруулах төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

### **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

**Жич:** Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

#### **4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хүний эрхийг хангах, хамгаалах хэрэгцээ, шаардлага байна. Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуульд нэмэлт оруулах төсөл боловсруулах нь зүйтэй болно.

#### **4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Зорилтот бүлгийн тэтгэврийг улсын дунджид хүргэснээр тодорхой зардал гарах боловч, тухайн иргэнд эрхээ эдлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, эерэг нөлөө үзүүлнэ.

#### **4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин төр засгийн үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоно.

#### **4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд "1. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусlamж авах эрхтэй;" Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд "2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно", Арван есдүгээр зүйлд "1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хуулийн зарчимд нийцэж байна.

Мөн энэ чиглэлээр хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь олон улсын хэм хэмжээний жишигтэй нийцэж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийцэж байна.

#### **ТАВ.ЗӨВЛӨМЖ**

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд оруулах шаардлагатай байгаа нэмэлтийг тусгахын тулд хуульд нэмэлт оруулах хэлбэрээр хуулийн төсөл боловсруулж батлан гаргах хувилбар нь тавьсан зорилтыг хангахаар байна.

-----оОо-----

## Хавсралт

### Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт,
- "Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал" НҮБ, ОУХБ, Монгол Улсын засгийн газраас 2015 онд хэвлүүлсэн тайлан
- Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны материал

### Хууль тогтоомжийн жагсаалт:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль
- БНМАУ-ын Тэтгэврийн хууль
- Улсын Их Хурлын 1999 оны 5 дугар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоол
- Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 53 дугаар тогтоол
- Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоол

2.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх 1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын

				хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр	
1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь түр хугацаагаар тэтгэвэр нэмэр асуудал биш байнга хэрэгжих асуудал юм.	
<b>1.2. Оролцоог хангах</b>				
1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Тэтгэврийн нэмэгдэл нь нийтэд хамаатай биш тодорхой нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон хүмүүст хамаарна.	
1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтыг бий болгосноор бусад хүний эрх ашиг сонирхол хөндөгдөхгүй.	
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				
1.3.1. Зохицуулалтын бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхияг хангах явцад ахиц гарна.	
1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр тодорхой зөвлөмж байхгүй.	

	зөвлөмжид байгаа эсэх	НИЙЦЭК			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагын асуудал хамаарахгүй.	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарлахгүй	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарлахгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Дагаж гарах хуулийн төсөлд Засгийн газар журам гаргахаар тусгасан.	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү здгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр	
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр	
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй	
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бурдуулэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.	

**ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
**(Хүснэгт 2)**

Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)				
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх				
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хундрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	

	худалдан авахад хүргэх эсэх			
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа хуульд заасан мэдээлэх тухай ажиллагаа хэвээр хадгалагдана. Ийимд нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хедлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Иноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	зээлийг ашиглах боломж олгох эсэх			
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа хуульд зааснаас өөрөөр нөлөө үзүүлэх зүйл байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шүүхийн байгууллагын системд ажлын байр бий болгох магадлалтай.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Байгууллагад шинэ нэлж үүсэх буюу шинээр орон тоо нэмэх магадлалтай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй

11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн зөрчилдөхгүй.
------------------------	----------------------------------------------------------	------	------	--------------------------

**НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ  
(Хүснэгт 3)**

Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл		1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр хамаарахгүй.
		1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх		2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
		2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал		3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөдөлгөөнд нөлөөлөх эсэх			
	6.3.Иргэдийн боловсрол (терийн болон хувийн хэвшилийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, вэрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ  
(Хүснэгт 4)**

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сергэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
4.Усны нөөц		4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцэд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол		5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй
		5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй

6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохицой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

----оо----